

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСЭЭС ӨГСӨН НИЙТЛЭГ
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2021.10.24

Хараат

№	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
1	Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн жагсаалтын дагуу хэрэгжүүлэх ажлыг жил бүр төлөвлөн хэрэгжилт үр дүнг тооцож байх.	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	АЗДТГ-аас 2021 онд хэрэгжих үндэсний 62, дэд 9 хөтөлбөрийн жагсаалтыг хариуцах албан хаагч тус бүрээр гаргаж байгууллага болон холбогдох албан хаагчдад хүргүүлсэн. Үүний дагуу 29 үндэсний хөтөлбөр, 6 дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.	70
2	Үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийн 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг ХШҮДАХ-т 1 дүгээр улиралд багтааж ирүүлэх /цахимаар/	Төлөвлөгөө гаргаж хүргүүлсэн байдал	АЗДТГ-аас 2021 онд хэрэгжих үндэсний 62, дэд 9 хөтөлбөрийн жагсаалтыг хариуцах албан хаагч тус бүрээр гаргаж байгууллага болон холбогдох албан хаагчдад хүргүүлсэн. Үүний дагуу 29 үндэсний хөтөлбөр, 6 дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг 12 сарын 10-ны дотор авахаар ажиллаж байна.	70
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн ИТХТ-ийн тогтоол, Засаг даргын захирамжийн тухайн сум, агентлагт хамааралтай заалтуудыг хяналтад авч хэрэгжилт үр дүнг тооцож тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж байх.	Хэрэгжилтийг хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлсэн байдал	Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр улиралд батлан гаргасан захирамжаас тус суманд хамааралтай 7 захирамжийн 7 заалтыг хяналтанд авч 75,7%-тай, 2 дугаар улиралд батлан гаргасан 19 захирамжийн 34 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулж 91,2%-тай, 3 дугаар улиралд батлан гаргасан 12 захирамжийн 15 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулж 97,8%-тай хэрэгжүүлж ажилласан байна.	100
4	Аймгийн Засаг даргын сайдтай байгуулсан гэрээ болон аймгийн Засаг даргын сум, хэлтэс агентлагийн дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийн байдалд хагас жилд	Хэрэгжилтийн хувь Авсан арга хэмжээний тоо	Дундговь аймгийн Засаг дарга, Цагаандэлгэр сумын Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг зохион байгуулж хагас жилийн байдлаар 68,7%-	70

	тутамд хяналт шинжилгээ хийж, хэрэгжилт удаашралтай байгаа заалтыг эрчимжүүлэх арга хэмжээ авч байх.		тай хэрэгжиж байна. Үүнээс хэрэгжилт удаашралтай байгаа 69, хугацаа болоогүй 9 ажил арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлийг холбогдох байгууллага, албан хаагчдад хурлын тэмдэглэлээр үүрэг болгосон. Жилийн эцсийн байдлаар гэрээний хэрэгжилтийн тайлан гараагүй байна.	
5	2018 оны Ерөнхийлөгчийн 46 дугаар зарлигийн /Монгол бичгийн хэрэглээг эрчимжүүлэх тухай/ дагуу албан хаагчдад сургалтыг тогтмол зохион байгуулж, албан хаагчдын мэдлэгийн түвшинг тодорхойлон, жилийн эцэст ахиц, өөрчлөлтийг үнэлж байх.	Сургалтын тоо Зохион байгуулсан арга хэмжээ	ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЗДТГ-ын гаднах хаяг үндэсний бичгээр бичигдсэн. “Хүмүүн бичиг” сонинг төрийн байгууллагууд улирал бүр захиалан уншиж байна. Төрийн албан хаагчдын монгол бичгийн түвшинг тогтоох “гарааны үнэлгээ” сорилыг зохион байгуулж, сорилын дүнг нэгтгэсэн. Үүнд 5 албан байгууллагын 70 албан хаагч хамрагдсан. Сорилын нэгтгэлийн дүнд тулгуурлаж анхан болон дунд шатны танхимын модуль сургалтыг зохион байгуулан хичээллэж байна. Анхан шат-44, дунд шат-26 албан хаагч тус сургалтад хамрагдаж байна. Д.Төмөр багшийн бэлтгэн хүргэдэг “Цахим монгол бичиг”-ийн хичээлийг төрийн албан хаагчид үзэн тэмдэглэл хөтөлж, гэрийн даалгавраа сумын албан хаагчдын нэгдсэн группэд байршуулж, сургагч багш нараараа хянуулан, шалгуулдаг. Сургагч багш нар тухайн албан хаагчийн идэвхи оролцоо, хичээлийн даалгаврын гүйцэтгэлийг хянаж, тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. “Дундговь аймгийн төрийн албан хаагчид групп” “Geriin daalgawar challenge”-д Цагаандэлгэр сумын байгууллага тус бүрийн албан хаагчид дуудагдсан хугацаандаа идэвхтэй хамрагдсан.	70
6	Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг тооцох.	Хэрэгжилтийн хувь	Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөөг 2 бүлэг, 16 заалттайгаар боловсруулж ЗДТГ-ын даргаар 2019.07.05-ны өдөр батлуулан хэрэгжилтийг жил бүр хагас, бүтэн жилээр тооцон ажиллаж байна.	100

			Улсын үзлэгээр өгсөн зөвлөмжийн дагуу архивын өрөөнд 2 төмөр шүүгээ, гэрлийн унтраалгыг гадна талд гаргаж, гэрлийг төмөр бүрхүүлтэй болгож, цонхонд хамгаалтын төмөр хийсэн. Хэвлэмэл хуудасны зарцуулалтын тооцоог хийж хэвшээд байна.	
7	Дотоод хяналт шалгалтыг байгууллагын албан хаагчдын ERP төрийн байгууллагын нэгдсэн системийн ашиглалтад хийх, үр дүнг тооцох.	Дотоод хяналт шалгалт хийсэн тоо, үр дүнгээр	Дотоод хяналтын багаас ERP төрийн байгууллагын нэгдсэн системийн ашиглалтын байдалд хяналт хийхэд 5 байгууллагын 58 алба хаагч бүртгэлтэй. Үүнээс тогтмол идэвхтэй хэрэглэж байгаа 22 албан хаагч байна. Цаашид бусад албан хаагчдыг системд идэвхтэй байх талаар байгууллагын удирдлагуудад үүрэг өглөө.	70
8	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах хүснэгтийн дагуу төлөвлөлтийг хийж, тайлан мэдээг тодорхой тоо баримт үр дүнтэйгээр гаргаж байх.	Хөтөлбөрийн биелэлтийн хувь, хүснэгтээр гаргасан байдал	“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2021.01.12-ны өдөр 4 бүлэг, 17 заалттайгаар “Төрийн албан хаагчийн сургалт”-ын хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 12 заалттайгаар батлан хэрэгжилтийг тооцож ажилласан байна. АИТХ-аар батлагдсан аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг Цагаандэлгэр суманд 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар 2021.08.16-ны өдөр 7 заалттайгаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байна. Засаг даргын Тамгын газрын 2021 онд ажлын байранд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөг 22 заалттайгаар баталж дотоод сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан.	100
9	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмыг албан хаагчдад судлуулан, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, түүний хэрэгжилтийг тайлагнах, үнэлэхэд мөрдөж ажиллах.	Журмыг судлуулсан байдал	Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон төрийн захиргааны 13 албан хаагчдыг ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтад	100

			хамруулж гэрчилгээ олгуулав. Сургалтанд хамрагдсанаар байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйг сурч мэдлээ.	
10	Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн өсөлт бууралтыг тооцож, бууралттай байгаа үзүүлэлтийг ахиулахад санаачлагатай ажиллах.	Зохион байгуулсан арга хэмжээ, түүний үр дүнгээр	2020 оны сжмын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн өсөлт бууралтыг тооцож, бууралттай байгаа 2 ажлын үзүүлэлтийг ахиулахаар төлөвлөгөөний дагуу ажилласан. 1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт иргэдийг хамруулах талаар ажилгүй иргэдэд 2 удаа сургалт зохион байгуулсан. Түр ажлын байранд хамрагдахаар 6 иргэн бүртгүүлсэн. 2. Сум хөгжүүлэх зээлийн сангийн журамд өөрчлөлт орсны улмаас зээлд хамрагдах материал ирүүлсэн хоршоо байхгүй. Өмнөх зээл авсан иргэдийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэхийн тулд иргэн бүртэй 2-3 удаа уулзаж цахимд мэдээлэл оруулсан. Нийт 27 иргэн зээлтэй. Үүнээс зээлийн хэтрэлттэй 5. Бусад иргэн, ААН-үүд хугацаанд нь төлж байрагдуулж байна.	70
11	Хэрэглэгч, иргэдэд зориулсан эрх зүйн гарын авлагуудыг боловсруулж цахимаар түгээх.	Зохион байгуулсан арга хэмжээ, түүний үр дүнгээр	АЗДТГ-аас 2021.05.11-ний өдөр сумдын эрх зүйн хөтөч нарт зохион байгуулсан албан бус сургалтанд 4 эрх зүйн хөтчийг хамруулж хөтчүүдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр дээшлүүлэх нь” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 13 заалттайгаар батлан хэрэгжилтийг зохион байгуулан төлөвлөгөөний дагуу ажиллалаа. Аяны хүрээнд эрх зүйн хөтчүүд цахим сүлжээгээр иргэд олон нийтэд хууль эрх зүйн мэдээ мэдээллүүдийг тогтмол хүргэн ажиллаж	100

			байна. Сумын 3 төрлийн цахим группэд 22 удаагийн давтамжтай мэдээлэл байршуулсан. Давхардсан тоогоор 153 хүний хандалт авсан байна. Багийн иргэдийн нийтийн хурал, өдөрлөг бусад арга хэмжээний үеэр ЗДТГ-аас 13 төрлийн гарын авлагыг боловсруулж 78 иргэнд хүргэж ажилласан байна.	
12	Төрийн захиргааны албан хаагчдын хувийн хэрэгт Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 04 дүгээр зөвлөмжийн хавсралтын дагуу сургалтын судалгааг гарган хийж байх.	Судалгааг гаргаж хувийн хэргийн бүрдэл	Албан хаагчдын хувийн хэрэгт ТА3-ийн 2020 оны 04 дүгээр зөвлөмжийн хавсралтад заасны дагуу сургалтын судалгааг гарган хийж албан хаагчдад танилцуулсан. ЗДТГ-ын 2021 онд ажлын байранд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөг баталж 22 сургалтаас 15 сургалтыг зохион байгуулаад байна.	100
13	Албан хаагч нарын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд бусад салбарын хууль тогтоомжуудаар эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулах.	Сургалтын тоо	Эрх зүйн хөтөч багаас 2021 онд байгууллага, албан хаагчидтай хамтран судлан сурталчлах хууль эрх зүйн актын нэгдсэн төлөвлөгөөг батлуулж 60 эрх зүйн актын талаар мэдээлэл өгөх, сурталчлахаар төлөвлөснөөс 3-р дугаар улирлын байдлаар танхимаар 3, цахимаар 17 удаагийн хууль, эрх зүйн сургалт мэдээллийг төрийн байгууллагын нийт 75 /Давхардсан тоогоор 198/ албан хаагчдад хүргэсэн. Иргэд олон нийтэд цахим сүлжээгээр хууль эрх зүйн мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна. 1-р багийн хөдөөгийн 17 малчин иргэдэд эрх зүйн богцыг аялуулсан байна. 4-р багийн иргэдийн нийтийн хурлын үед 78 иргэдэд 13 төрлийн гарын авлага боловсруулж мэдээлэл хүргэсэн байна. 2-р баг дээр зохион байгуулсан мал эзмэгжүүлэлтийн нээлтийн үеэр 23 малчдад хөдөө аж ахуйн чиглэлийн мэдээлэл хүргэж ажилласан байна.	70
14	Сахилгын арга хэмжээ ногдуулсан тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөх.	-	ЗДТГ-ын 2 үйлчилгээний албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан. Захиргааны ерөнхий хуулийн 27-р зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг	100

			зохион байгуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	
15	Архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандартыг судлан хэрэгжүүлж, Архивын тасгаас ААХХ-ийн иж бүрэн сургалт авах.	Сургалтын тоо	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан журам, дүрмийг сурталчлан таниулах 3 сарын аяны төлөвлөгөө, удирдамж, сургалт хийх графикыг боловсруулан ЗДТГ-ын даргаар батлуулан 2021.03.10-2021.05.16-ны өдрийн хооронд зохион байгуулж явуулсан байна. Үүнд: 1.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, 2.Баримт бичгийн стандарт, 3.Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын талаар сургалтыг зохион байгуулж гарын авлага, боршур хийж, нийт 36 төрийн албан хаагч хамрагдлаа. Архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, шинэ стандартын талаар албан байгууллагын дарга, эрхлэгч, албан хаагч нарт 2 удаа цахимаар сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 25 албан хаагч хамрагдсан байна. 2021 оны 09-р сард Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан “Баримт бичигт нягтлан шалгалт хийх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах” сэдэвт 2 хоног цахим сургалтанд хамрагдсан. Байгууллагаас 50000 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.	100
16	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроохгүй чанартай оруулж хэвших.	Хугацаа, тоо	Төсөвт байгууллагууд болон Эм эргэлтийн сан нийт 7 байгууллагын хэмжээнд жилийн эцсийн байдлаар шилэн дансны нийт 1043 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 966 мэдээлэл, хугацаа хэтэрсэн 63 мэдээлэл байна. Мэдээлэл байршуулах хугацаа нь болоогүй 14 мэдээлэл байна. Эдгээр мэдээлэл нь байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит хийгдсэний дараа мэдээлдэг тул дараа оны 4 сарын 25-ны дотор санхүүгийн баталгаажсан тайлан болон аудитын дүгнэлтийг	100

			байршуулна. Огт байршуулаагүй мэдээлэл байхгүй.	
17	Аймгийн сайтад мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол чанартай оруулж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажиллах.	Мэдээ оруулсан тоо	Аймгийн сайтад цэцэрлэгээс 3, ЕБС-иас 1, ЭМТ-өөс 1, ЗДТГ-аас 20, орон нутгийн мэдээн дээр 3, нийт 30 мэдээллийг байршуулж иргэдийг мэдээллээр хангаж ажиллалаа.	70
18	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системээр бүртгэж, бүртгэл хяналтын карт хөтлөн ажиллах.	Тоо	Сумын хэмжээнд төсөвт байгууллага, албан хаагчдад иргэдээс ирүүлсэн 164 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан байна. Үүнд: хүсэлт-29, санал-30, гомдол-14, бичгээр-34, утсаар-35, амаар биечлэн-22 ирснийг хүлээн авч шийдвэрлэлээ. ЗДТГазарт бичгээр 19 өргөдөл ирснийг хүлээн авч хяналтын карт хөтлөж, цахимд системд бүртгэж ажилласан байна.	100
19	Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан заавар, аргачлалаар албан хаагчдадаа сургалт зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.	Сургалтын тоо	Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон төрийн захиргааны 13 албан хаагчдыг хамруулан ЗГ-ын 2020 оны 217-р тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, 218-р тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын талаар танилцуулга мэдээлэл хийж зохих заавар зөвлөгөөг өгч ажилласан.	70
20	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаат мэдээ тайлангийн хуваарийг мөрдөж, АЗДТГ-ын холбогдох хэлтэст хугацаанд чанартай тайлагнах.	Хугацаанд нь тайланг явуулсан байдал	2021 оны эхний хагас жилийн байдлаар ТЗУХ-т аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хагас жилийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын 2021.03.05-ны өдрийн 1/374 тоот албан бичгээр өгсөн “Чиглэл хүргүүлэх тухай” албан тоотын хэрэгжилт, аймгийн Засаг даргаас 2021 оны 1, 2 дугаар улиралд батлан гаргасан захирамжийн хэрэгжилт, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга. Засаг дарга нарын нэгдсэн уулзалт, семинарын	100

		мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг тус тус хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар тайлангийн хэрэгжилтийг гарган ажиллаж байна.	
Дундаж үнэлгээ 100%-11, 70%-9			86,5%

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН: НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

О.НАНДИН-ЭРДЭНЭ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

З.СОЛОНГО

ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА

Д.БУДЖАВ